



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 14 өдөр

Дугаар A/186

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 4 дүгээр багийн Бөхөн шарын Тарвагатай амнаас Цагаан суваг хүртэлх 4 км зам, Нарийн амнаас Бүрд хүртэлх зам дагуу жалга гарам засссан зам засварын ажлын гүйцэтгэлийг тус тус хүлээн авах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)

Гишүүд: Г. Пүрэвтогтох (З дугаар багийн Засаг дарга)

Г.Сугар (Эрх зүйн хөтөч)

Г.Бүд (Засаг даргын Тамгын газрын нярав)

Э.Буяントогтох (Хөдөө аж ахуйн тасгийн

мэргэжилтэн)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдлыг хянан үзэж, гэрээний шаардлагыг биелүүлсэн нөхцөлд акт үйлдэж хүлээн авч танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Н.Орхонтуул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН